

■ ЖАЙКА-ГИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

<ul style="list-style-type: none"> • <u>Овог нэр (Албан тушаал)</u> Кобаяши Мияако (Хүний хөгжлийн газрын дэд дарга бөгөөд Суурь боловсролын хэлтсийн дарга) • <u>Мэргэжил, ажлын туршлага</u> Аспирантураа дүүргэсэн 1998 оноос хойш ЖАЙКА-д алба хашиж байна. Далайн чанад дахь залуу сайн дурын гишүүдийн газар, Бангладеш дахь төлөөлөгчийн газар, ЮНЕСКО-гийн далайн чанад дахь урт хугацааны сургалтын хэлтэс, Хүний хөгжлийн газар, Буцалтгүй тусламжийн газарт боловсролын дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажилласан байсан. 2022 оны 02 дугаар сараас ЖАЙКА-гийн “Боловсролын мэдлэгийн менежментийн сүлжээ (KMN)”-нд менежерийн албыг давхар хашиж буй. • <u>Монголын багш нарт илгээсэн мэндчилгээ</u> “Миний бие техникийн хамтын ажиллагаа, буцалтгүй тусламжийн ажлаар Монголд 3 удаа ирж ажилласан. ЖАЙКА-д “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг хариуцаж байв. 2011 онд Завхан зэрэг аймагт томилолтоор ажиллахдаа ЖАЙКА-гийн мэргэжилтэн бараг очдоггүй хөдөөгийн багш нар хичээлийн судалгаа хэрхэн хичээнгүйлэн хийж буйг хараад ихэд сэтгэл хөдөлж билээ. Энэ удаа та бүхэнтэй хамт Монголын хичээлийн судалгааны хэрэгжилт, ахиц дэвшилтэй танилцахдаа баяртай байх болно.” 	
<ul style="list-style-type: none"> • <u>Овог нэр (Албан тушаал)</u> Хаяаши Кэнго • <u>Мэргэжил, ажлын туршлага</u> Их сургуулиа төгссөний дараа, 2020 оноос хойш ЖАЙКА-д ажиллаж байна. ЖАЙКА-гийн Япон дахь үйл ажиллагааг хариуцсан байгууллага (ЖАЙКА Чюүбү бүс) болон Хүний хөгжлийн газарт боловсролын чиглэлээр ажилласан. Одоо Хүний хөгжлийн газрын Суурь боловсролын хэлтэст тэгш хамран сургах боловсрол, байгалийн ухаан, математикийн боловсрол хариуцаж байна. Ялангуяа Монгол Улсад хэрэгжиж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн II шат (СТАРТ-2) болон “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн II шатны нэмэлт дэмжлэгийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг. • <u>Монголын багш нарт илгээсэн мэндчилгээ</u> “Өнгөрсөн оны 6 дугаар сард Монголд очиход халуун дотноор хүлээн авсан, ЖАЙКА-тай олон жил хамтран ажиллаж буй та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье. Монгол Улс дахь хичээлийн судалгааны үйл ажиллагаатай танилцах, та бүхэнтэй дахин уулзахыг тэсэн ядан хүлээж байна.” 	

■ ЖАЙКА-ГИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД МОНГОЛД АЖИЛЛАХ ТУХАЙ

ЖАЙКА нь 2006-2013 онд 7 жилийн хугацаанд, техникийн хамтын ажиллагааны “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг 2 үе шаттай хэрэгжүүлсэн.

Төслийн эхний шатанд (2006-2009 он), боловсролын шинэ стандартад нийцсэн багшлахуйн арга зүйн зөвлөмж, зөвлөмж боловсруулах гарын авлага боловсруулах дэмжлэгийг үзүүлж, төслийн II шатанд (2010-2013 он) багш нарт багшлахуйн шинэлэг арга зүй түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх, “Хичээлийн судалгаа”-г Монголд нэвтрүүлэх үйл ажиллагааг голлон хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам нь уг төсөл дууссаны дараа ч төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулж ирсэн ба 2012 онд байгуулагдсан Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын арга зүйчдийг чадавхжуулахад анхаарч ажиллахын зэрэгцээ арга зүйчид ЕБС-ийн багш нарын багшлахуйн арга зүй, хичээлийн судалгааг чиглүүлэн ажиллах тогтолцоо бүрдсэн. Мөн хичээлийн судалгааны арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (МХСН)” ТББ-ыг 2013 онд үүсгэн байгуулж, хичээлийн судалгааны сургагч багш бэлтгэх сургалт, мониторингийн үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн төдийгүй, багш нарт зориулсан Япон дахь сургалтыг өнөөг хүртэл нийт 9 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 160 хүнийг хамруулжээ. Шинэ хэлбэрийн коронавирусын халдварт цар тахлын өмнө, жил бүр хичээлийн судалгааны олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж байв.

Энэ жил буюу 2023 онд “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн II шат дууссаны 10 жилийн ой тохиож байна. Уг төсөл хэрэгжиж дууссанаа дараа ч үр дүнг нь түгээн дэлгэрүүлсээр ирсэн загвар төсөл болсон бөгөөд хойшид ч Монгол Улсад “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн I, II шатны үр дүнг үр өгөөжтэй ашиглуулах үүднээс хамтын ажиллагааныхаа өмнөх ололт амжилтыг дахин бататгаж, цаашид улам бүр өргөжүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулахаар тогтсон.

Мөн энэ удаа Монголд ажиллах дашрамд, одоо хэрэгжиж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн II шатны 4 дэх удаагийн Хамтарсан зохицуулах зөвлөлийн хуралд оролцоно. Төсөл дуусах (2024 оны 08 дугаар сар) дөхөж буйтай холбогдуулан, энэ удаагийн хурлыг тэгш хамран сургах боловсролыг тасралтгүй хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх уулзалт болгохыг хүсч байна.

Монголд ажиллах хөтөлбөр (төсөл)

Сар өдөр	Төлөвлөгөө
05 дугаар сарын 17 (Лха)	Монголд ирэх
05 дугаар сарын 18 (Пү)	(Үдээс өмнө) Нээлттэй семинар / (Үдээс хойш) Их сургуулийн профессорын лекц
05 дугаар сарын 19 (Ба)	БШУЯ-ны холбогдох албаны хүмүүстэй хийх уулзалт Монголын хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний бага хурал (Өдөр 1)
05 дугаар сарын 20 (Бя)	Монголын хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний бага хурал (Өдөр 2)
05 дугаар сарын 21 (Ня)	
05 дугаар сарын 22 (Да)	СТАРТ-2 төслийн Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурал
05 дугаар сарын 23 (Мя)	Нутаг буцах